



ИРГЭДИЙН АЛТЯАНС ТӨВ

Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгааллын ЭВСЭЛ

Баримтжуулалтын тайлан

Улаанбаатар хот
2008 он

Тайлан бэлтгэсэн:

П. Бадамрагчаа
А. Түвшинтулга
Б.Цэнд-Аюуш
Д. Саруул
Ц. Мөнхбат

Хянан тохиолдуулсан:

Д.Цэнд-Аюуш
Т.Ундарьяа
Ж.Занаа



"BCI" Хэвлэлийн КОМПАНИ
Утас: 319032

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын ардчилал, хүний эрхийн баталгааг жинхэнэ утгаар нь шалгасан 2008 оны 7-р сарын 1-ний өдөр Монголын түүхэнд ямар нэг байдлаар тэмдэглэгдэн үлдэх нь дамжиггүй. Монгол орон Азийн ардчиллын өлгий нутаг хэмээн нэрлэгдэн 18 жил өнгөрч, Үндсэн хуулиараа хүний амин чухал эрхийг бараг бүгдийг баталгаажуулсан бөгөөд хүний эрхийн талаар соёрхон баталсан хүний эрхийн гэрээ конвенцууд, хуульчлан гаргасан бичиг баримтаараа тэргүүлэх орны нэг болжээ.

Гэвч дээр дурдсан хууль тогтоомжууд нь ардчиллын тулгуур зарчим болсон хүний эрхийн баталгаа болж чадахгүй байгааг түүнчлэн Монголд ардчиллыг төлөвшүүлэхэд ноцтой саад учруулж буй гүн гүнзгий учир шалтгаан, хүчин зүйлс буйг энэ нэгэн өдрийн үйл явдал бэлхнээ харууллаа. Монгол улс түүхэндээ анх удаа олон нийтийн дэг журам алдагдсантай холбоотойгоор “Онц байдал” зарласан нь бас нэгэн түүхийн бичлэг болов. Үнэндээ энэхүү шийдвэр нь Монголын нийгмийн эд эс бүхнийг цочроосон асар өргөн цар хүрээтэй үйл явдал болж өрнөнө гэж Онц байдал зарлах үед хэн ч төсөөлөөгүй.

Энэ үйл явдал Монголын төрийн чансааг төдийгүй иргэний нийгмийн чадавхийг сорьсон явдал боллоо. Сүүлийн 18 жилийн хугацаанд хотод голчлон хэлбэршиж буй иргэний нийгэм маань хэр боловсорч чадавхжсан, хүний эрх жинхэнэ ёсоор бат суурьтайгаар хамгаалагдах тогтолцоо, ухамсар бүрэлдэн бий болж чадав уу?

Онц байдал зарласан нөхцөлд хүний эрх зөрчигдөх магадлал маш өндөр байдгийг хүн төрөлхтний түүхэн туршлага олонтаа харуулсан. Иймд хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг 20 гаруй ТББ хамтран 2008 оны 7-р сарын 1-нээс 2-нд шилжих шөнөөс эхэлсэн 4 хоногийн Онц байдлын үеэр эвсэлдэн нэгдэж үйл ажиллагаа явууллаа.

Тус эвслээс өөрийн зорилгыг: Онц байдал зарлаж, хоморголон баривчилж, түр саатуулан хорих явцад гарч байгаа буюу гарч болох хүний эрхийн зөрчлийг баримтжуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, баривчлагдагсад эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэдийг үнэн бодит мэдээллээр хангаж, төрийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн хяналт тавих хэмээн тодорхойлсон.

Гэсэн хэдий ч үүссэн нөхцөл байдалд иймэрхүү үйл ажиллагаа тэр тусмаа засаг, төрийн байгууллагад ажиллаж байгаа албан тушаалтнуудын хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэх байр сууринд байх нь бүх талаараа улс төрийн хардлага сэрдлэг дагуулах эрсдэлтэй байлаа. Цаг хугацааны болон нөөц боломжийн хувьд харьцангуй бэлэн бус байсан тул эвсэл өөрсдийн боломжит нөөц бололцоонд тулгуурлан энэхүү арга хэмжээг авч явууллаа.

Иргэний нийгмийнхний зүгээс өмнө нь тариаланчдын цуглааныг хүчээр тараах үеэр зарим нэг баримтжуулалт хийж байсныг эс тооцвол хүний эрхийн зөрчлийг баримтжуулах өргөн хүрээний иймэрхүү яаралтай ажлын туршлага багатай байв. Тийм ч учраас энэхүү баримтжуулах үйл ажиллагаа нь эвслийн гишүүдийн хувьд томоохон сургамж болсон төдийгүй бидэнд аливаад бэлтгэлтэй, сонор сэрэмжтэй байхыг санууллаа.

Энэ дашрамд онц байдал тогтоон хүн бүрийн оюун санаа сэтгэл зүрхэнд айдас түгшүүр бий болсон цаг үед хүний эрхийн зөрчлийн мониторинг хийхэд хэсэг хугацаанд хувийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ажил, ар гэрийн амьдралын хувьд эрсдэлтэй нөхцөлд сэтгэл зүрх, цаг зав, боломж бололцоогоо дайчлан ажилласан бүх хүнд талархал илэрхийлье.

Баримтжуулалтын баг

¹ Эвсэлд нэгдсэн иргэний нийгмийн байгууллагуудын нэрсийг хавсралтаас харна уу.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ ОНЦ БАЙДАЛ ТОГТООХ ТУХАЙ²

2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр, Улаанбаатар хот

Дугаар 194

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүлэг хүмүүсийн хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн эмх замбараагүй байдал үүсч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад халдан амь насанд нь заналхийлж, эд хөрөнгө устгах, галдан шатаах үйл ажиллагаа даамжирч нийтийн эмх замбараагүй байдал бий болсон тул энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т³ заасан бүрэн эрхийнхээ дагуу, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсгүүдийг⁴ баримтлан нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2008 оны 7 дугаар сарын 1-ний 24.00 цагаас эхлэн 4 хоногийн хугацаанд онц байдал зарласугай.

Онц байдлыг зарласан хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй:

1. Улсын онц чухал болон хүн амын амьжиргааны хангамжийн объектуудыг хүч нэмэгдүүлэн хамгаалах,
2. Хууль тогтоомж зөрчиж зохион байгуулсан жагсаал, цуглаан, олон нийтийн бусад арга хэмжээг **хуульд заасан арга, хүч хэрэгслээр шууд албадан тараах,**
3. Улаанбаатар хотын төвийн хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдгээрт үзлэг хийх,
4. **Нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн эвсэг, техник хэрэгслийг хураан авах,**
5. **Улаанбаатар хотын төвийн хэсэг (Бага тойруу) 22.00- 08.00 цагийн хооронд хөл хорьж, зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах,**
6. Дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хориглох, шаардлагатай бол түр хураан авах, **Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онцгой байдлыг цуцлах хүртэл зогсоох,**

² Зарлигийг www.legalinfo.mn сайтаас татаж авав.

³ ҮХ-ийн 33.1.12т: Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно

⁴ Онц байдлын тухай хуулийн 5-р зүйл:

3. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт бий болсон бөгөөд үйл явцын өрнөлт нь онц байдал нэн даруй зарлахыг шаардаж байгаа хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч Онц байдал зарлах тухай зарлиг гаргана.
6. Онцгой нөхцөлийн үйл явцын өрнөлт нь онц байдал нэн даруй зарлахыг шаардаж байгаа хойшлуулшгүй тохиолдолд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан урьдчилан сануулах арга хэмжээг авалгүйгээр онц байдал зарлана.

7. Согтууруулах ундааны зүйл худалдах, тараахыг хориглох,
8. Иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн технологид хэрэглэдэг тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтад хяналт тогтоох.
9. Энэхүү зарлигийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг Онц байдлын тухай хууль болон бусад хуулийн хүрээнд холбогдох байгууллагуудын хүч хэрэгслийг дайчлан удирдан зохион байгуулж ажиллахыг Хууль зүй дотоод хэргийн сайд (Ц.Мөнх-Оргил)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

2008 оны 7-р сарын 1-ний 23 цагт Монгол улсын Ерөнхийлөгч телевиз, радиогийн хэрэгслээр онц байдал зарлаж байгааг мэдэгдэв⁵. Онц байдлыг 2008 оны 6-р сарын 29-нд болж өнгөрсөн Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараагаар өрнөсөн олон нийтийн эсэргүүцлийн жагсаал цуглаан болон олон нийтийг хамарсан зөрчилдөөнт байдлын хариуд зарласан бөгөөд энэхүү арга хэмжээ, түүний урьтал болсон үйл явдлын аль аль нь Монголын ардчиллын түүхэнд анх удаа гарсан билээ. Сүүлийн 18 жилд ийм үйл явдал, нөхцөл байдалтай учраагүй Монголын нийгэм ихэд цочирдож, үүссэн нөхцөл байдлын учир шалтгаан, үр дагавар, төрийн зүгээс авсан арга хэмжээг бодитойгоор үнэлэн дүгнэж, ардчилсан хүмүүнлэг нийгмийн үндсэн зарчмуудын дагуу нийгмийн эрх ашигт бүрэн нийцсэн шийдвэр гаргаж чадахгүй байсаар даруй 4 сар өнгөрч байна.

Энэ үед бид онц байдлын үеэр хийсэн баримтжуулалтынхаа тайланг танилцуулахдаа олны анхаарлыг хүнээ дээдэлдэг нийгмийг бүтээхийг зорин олноороо хэлэлцэн баталсан Монголын Улсын Үндсэн Хууль, дэлхийн хүн төрөлхтний салшгүй нэгэн хэсэг гэдгээ батлан Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, тэдгээрээр баталгаажсан хүний эрх, ардчиллын суурь зарчмуудад дахин хандуулахыг хүсч байна.

Чингэхдээ бид ардчилсан нийгэмд төрийн гүйцэтгэх үндсэн үүрэг, онц байдлыг зарлахтай холбоотой олон улсын хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжид суурилан хийсэн дүн шинжилгээгээ танилцуулах болно. Үндэсний хууль тогтоомж нь олон улсын хууль гэрээ, конвенциас зөрүүтэй байгаа тохиолдолд олон улсын гэрээ, конвенцийн заалтыг ашиглана хэмээн Монгол Улсын Үндсэн Хуульд заасан байдаг тул бид олон улсын хэм хэмжээг голчлон суурилахын зэрэгцээ онц байдлын үеэр төрийн байгууллага, албан хаагчдын зүгээс үндэсний хууль тогтоомжийг хэрхэн зөрчсөнийг болон Монголын зарим хууль, эрх зүйн актууд, ялангуяа баривчлан саатуулах байруудын дотоод журмууд үндэсний болон олон улсын хууль, тогтоомжийг хэрхэн зөрчиж буйг анхаарсан болно.

⁵ 2008 оны 7-р сарын 1-ний 20 цагт хийсэн мэдэгдлээрээ зайлшгүй тохиолдолд онц байдал зарлах тухай мэдээлсэн гэвч гудамжинд жагсаж эмх замбараагүй байдалд оролцсон буюу телевиз радиогоор мэдээлэл авах боломжгүй байсан бусад иргэдийн хувьд энэ мэдээлэл яаж хүрсэн нь тодорхойгүй.

ТӨР БА ХҮЧИРХИЙЛЭЛ

Аливаа нийгэмд төрийн үндсэн үүрэг нь иргэдээ гадна, дотнын заналхийллээс хамгаалж, аюулгүй байдлыг нь хангах явдал юм. Ардчилсан нийгэмд хүний аюулгүй байдлыг хамгаалах гэдгийг хүний жам ёсны эрх, эрх чөлөөг чандлан хамгаалах утгаар ойлгодог. Аюулгүй байдлыг хангах энэхүү онцгой үүргийг хүлээснийхээ төлөө төр нийгэмд хүчирхийллийн монополийг (шүүх, цэрэг, цагдаа гэх мэт албадлагын институцуудыг ажиллуулах замаар) эзэмших онцгой эрхийг эдэлдэг. Мөн энэхүү үүргээ болон орчин үеийн төрийн хөгжлийн явцад нэмэгдэж ирсэн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхийн тулд төр нь иргэдийн татвараар санхүүждэг.

Гэвч аливаа нийгэмд, ялангуяа иргэдийн хяналт сул, ардчилсан засаглалын институцууд бэхжээгүй, нийгмийн эд баялаг, эрх мэдэл хэт тэгш бус хуваарьлагдсан нийгэмд төр хүчирхийллийн монополийг эзэмших давуу эрхээ урвуулан ашиглаж, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах бүү хэл иргэдийнхээ эрх, эрх чөлөөнд бүдүүлгээр халдах явдал түгээмэл гардаг билээ. Үүнийг Монголын төдийгүй дэлхийн олон орны олон жилийн түүх бэлхнээ харуулж ирсэн.

Тийм ч учраас иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг төрийн дур зоргоороо авирлах явдал, хариуцлагагүй үйлдлээс хамгаалахын тулд олон улсын хууль болон улс орнуудын үндсэн хуулиар ямар ч нөхцөлд иргэд баталгаатай эдлэх ёстой хүний эрхүүдийг тодорхой зааж өгсөн байдаг.

Энгийн үед ч төрийн зүгээс иргэдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж, эрх, эрх чөлөөнд нь ноцтойгоор халдах эрсдэл өндөр байдаг тул онц байдал зарласан нөхцөлд энэ эрсдэл улам бүр өндөр болдог билээ. Учир нь онц байдлын үеэр төр иргэдийн хяналтаас улам бүр хамгаалагдаж, төрийн эрх барьж буй цөөн тооны этгээд хэвийн үед эдэлдэг эрх мэдлээсээ хамаагүй илүү эрх эдэлж, нийгмийн аюулгүй байдлыг хангах нэрийдлээр иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн үйл ажиллагааг хянах, шүүмжлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан хийх зэрэг иргэний болон улс төрийн эрх, түүнчлэн амьд явах, эрүү шүүлтээс ангид байх, хуулиар хамгаалуулах, гэм буруу нь тогтоогдоогүй нөхцөлд гэм буруугүйд тооцогдох зэрэг суурь эрхүүдийг зөрчиж, иргэдийг хэлмэгдүүлэх явдал хавтгайрах аюул учирдаг.

Тийм учраас олон улсын болон үндэсний хууль тогтоомжуудаар онц байдлыг зарлах шалгуурыг маш өндөр тавьж, онц байдлыг аль болох зарлахгүйгээр тухайн нөхцөл байдлыг зохицуулахыг сануулж, онц байдал зарласан тохиолдолд хүний эрхийн хамгаалалтанд онцгой анхаарахыг шаарддаг.

ОНЦ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактанд (1966) **үндэстэн оршин тогтноход аюул заналхийлэх хэмжээний, нөхцөл байдлыг сайжруулахад ердийн арга хэрэгслүүд илэрхий хангалттай бус** нийгмийг хамарсан онцгой байдал үүссэн нөхцөлд онц байдал зарлаж, зарим хязгаарлагдмал арга хэмжээг (limited measures) авч болно гэж заасан байдаг.

Онц байдлын арга хэмжээг зөвхөн нөхцөл байдлын хойшлуулшгүй шаардлагаар хэрэглэх ёстой. Арга хэмжээ нь аливаа ялгаварлан гадуурхалтын эсрэг байна.

Мөн аливаа үйлдэл нь хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа доорхи үндсэн зарчмыг баримтална:

- Хүний үндсэн эрхэд (амьд явах, эрүү шүүлтээс ангид байх, боолчлолоос ангид байх г.м.) ямар ч тохиолдолд үл халдах

- Нийгмийн сайн сайхны төлөө буюу олон нийтийн амгалан тайван байдлын төлөө гэсэн хууль ёсны зорилготой байх
- Илүү ноцтой үр дагавраас зайлсхийсэн байх (авагдсан арга хэмжээ болон түүнээс үүдэн гарах үр дагаврыг сайтар тооцож зайлшгүй гэсэн тохиолдолд л онц байдал зарлах)
- Түр зуурын шинжтэй байх (тодорхой хугацаатай байх ба шаардлагагүй тохиолдолд аль болох хугацаа сунгахгүй байх)

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигт хүний хэд хэдэн эрхийг хязгаарласан хэдий ч хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ямар ч тохиолдолд хүч хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зэрэг чухал санамжуудыг дурдаагүй нь харамсалтай. Нөгөө талаас нэгэнт үйл явдлын өрнөл хэн бүхний хувьд тодорхой болсон цаг мөчид энэ бүх хохирол учрахаас урьдчилан сэргийлж зохих арга хэмжээг авах боломж байлаа. Гэвч өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгчээр харанхуй шөнийг хүлээх мэт шөнө дунд онц байдал зарлагдлаа.

Онц байдал зарлах нь өөрөө ямар ноцтой үр дагавар авчирч болохыг бид бусдын туршлагаас мэдэж байлаа. Олон улсын хэмжээнд нэгдэн орсон конвенц, түүний дагуу баталсан дотоодын хууль тогтоомжид ч энэ асуудлыг зохицуулсан байдаг. Онц байдлын талаар олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд үндсэн зарчмуудыг доорхи байдлаар тусгасан байдаг:

ИУТЭОУП⁶-ын 4-р зүйл:

1. Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар ***хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байх*** ёстой.
2. *Энэ заалт нь энэхүү Пактын 6, 7, 8, (1, 2 дахь хэсэг), 11, 15, 16, 18 дугаар зүйлээс ямар нэгэн байдлаар ухрах үндэслэл болохгүй.*
3. *Ухрах эрхээ хэрэгжүүлж буй, энэхүү Пактад оролцогч аливаа улс ухарч байгаа заалт болон ухрах болсон шалтгааны талаар уг Пактад оролцогч бусад улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан даруй мэдэгдэх ёстой. Түүнчлэн ухарсан үүргээ сэргээсэн хугацааг мөнхүү зуучлагчаар уламжлан мэдэгдсэн байх* ёстой

Энд конвенцоор хамгаалагдсан эрхүүдээс ухарч байгаа тохиолдолд аль эрхийг ямар төвшинд хязгаарлаж байгаагаа тодорхойлж НҮБ-д мэдэгдэх ёстой байсан атал манай улсын хувьд үүргээ биелүүлээгүй байна. Мөн аливаа улс энэ заалтыг урвуулан ашиглахаас сэргийлж доорхи заалтыг ч оруулсан байдаг.

5-р зүйл:

1. *Аливаа улс, бүлэг буюу хувь этгээд энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх, эрх чөлөөг үгүй хийх буюу тэдгээрийг түүнд зааснаас илүү хэмжээгээр хязгаарлахад чиглэсэн*

⁶ Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт

үйл ажиллагаа явуулах буюу үйлдэл хийх эрхтэй мэтээр энэхүү Пактын заалтуудыг мушгин тайлбарлаж болохгүй.

2. *Энэхүү Пактад оролцогч аливаа улсад хууль, конвенц, журам, заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу хэрэгжүүлж байгаа хүний аливаа үндсэн эрхийг тус Пактад хүлээн зөвшөөрөөгүй буюу доогуур хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн гэх шалтгаар хязгаарлах буюу бууруулж болохгүй.*

Онц байдал зарласнаар хүний эрх эрх чөлөөнд төрөөс халдах боломж нээгддэг. Энэ халдлага нь зохих хэмжээнд байх ёстой. Олон улсын эрх зүйд тухайлан хэзээд зөрчиж үл болох эрхийн тоонд оруулсан ч онц байдлын үед зөрчигдөхөд ойрхон байдаг хамгийн эмзэг эрхүүдэд:

- Хүний амьд авах эрх
- Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрх
- Хэнийг ч дур мэдэн баривчлахгүй байх,
- Баривчлагдан саатуулагдсан үед хэнтэй ч хүнлэг ёсоор харьцах, эрүүдэн шүүхээс ангид байх тухай эрхүүд орно. Учир нь төр өөрөө хүний эрх, эрх чөлөөг гол зөрчигч байдаг тул илүү ноцтой нөхцөл байдал үүсгэдэг юм.
- Ийм учраас ИУТЭОУП-ын 4-р зүйлийн 2-т онц байдлын үед дээр дурдсан заяамал эрх, эрх чөлөөг зөрчиж болохгүйг сануулсан байдаг.

Монгол улсын үндэсний хууль тогтоомжид онц байдал тогтоох тухайд Монгол улсын Үндсэн хуулийн 19.2-т: *Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө хэмээн заажээ. Ийнхүү олон улсын эрх зүйн зарчим Монгол улсын Үндсэн хуульд тодорхой хэмжээнд тусгагдсан байна гэж үзэж байна.*

Түүнчлэн 1995 онд Онц байдлын тухай тусгай хууль батлагдсан бөгөөд тус хуулийн 3-р зүйлд: *Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал хэмээн тодорхойлжээ.*

Түүнчлэн Онц байдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу **Үндэсний аюулгүй байдлын зөвлөл** нь *“Онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, явцад нь хяналт тавьж, биелэлтийг хангуулах шаардлагатай арга хэмжээ авна”* хэмээн заасан.

Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн баримт бчигүүдэд онц байдлын талаар дурдахдаа гол нь хүний эрхийн хамгаалалд анхаарал хандуулахыг зөвлөсөн байдаг. Харин Монгол улсын дотоодын хууль тогтоомж тэр дундаа 1995 онд батлагдсан Онц байдлын тухай МУ-ын хуулийг авч үзвэл зорилгоо: *“Энэ хуулийн зорилт нь онц байдал зарлах үндэслэл, журам, онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ, онц байдлыг хэрэгжүүлэх байгууллагын*

бүрэн эрхийг тогтоож, онц байдал зарласантай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон байдаг. Харин хүний эрх хамгаалах талаар тусад нь бүлэг болгон дурдсан ч хэрхэн яаж буюу хүний эрхийг хамгаалах арга замыг дурдаагүй. Жишээ нь: онц байдал зарлах тухай шийдвэрт заавал дурдах ёстой зүйлд хүний эрхийг хамгаалах, аливаа хязгаарлалтыг хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх тухай оруулаагүй нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл олон улсын баримт бичигт дурдсан заалтыг хэлбэрийн төдий хуулбарласнаас бус хэрхэн хэрэгжүүлэх талаар энэ хуулиар болон холбогдох заавар журмын хүрээнд тодорхойлоогүй байна

Цаашид Үндсэн хуулийн 19.2 –ыг үндэслэл болгон онц байдлын үед тусгайлан хууль баталж хүний эрх, эрх чөлөөний баталгааг улам чангатгах нь зүйтэй. Одоогийн мөрдөж байгаа Онц байдлын тухай хууль нь тухайн нөхцөл байдалд төрийн эрх мэдлийг яаж ч хэтрүүлэн хэрэглэхэд нээлттэй, цаг үеийн хувьд хоцрогдсон, асуудлыг шийдвэрлэх олон арга замыг орхигдуулсан зэрэг дутагдалтай байна.

ЭВСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА: БАРИМТЖУУЛАЛТ

Онц байдал зарласантай холбоотойгоор ерөнхийлөгчийн зарлигийн дагуу онц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд:

- **Жагсагчдыг хүч хэрэглэн тараах:** дотоодын цэргийн нэмэлт хүчний тусламжтайгаар эмх замбараагүй байдлыг зэвсэг хэрэглэн тараах оролдлого хийж эхэлсэн. Үүнээс үүдэн байлдааны болон сургуулийн суманд оногдож хүнд хөнгөн гэмтсэн иргэд олон байна.
- **Баривчлах:** жагсаал цуглаанд оролцсон болон тухайн газар нутагт явж байсан иргэдийг хоморголон баривчилж эхлэв. Олноор хоморголон баривчлах үйл явц газар нутгийн хувьд тэлсээр зарлигт дурдсанаас өөр газар явж байсан болон жагсаал, цуглаанд хамааралгүй иргэдийг баривчилж эхэлсэн.
- **Олон нийтийн радио телевизээс бусад телевиз радиогийн нэвтрүүлгийг хаах:** олон нийтийн радио телевизийг хүчтэй цензурын дор ажиллуулж эхлэв, телевизээр мөрдөн мөшгих яллах ажиллагаа явуулж эхэллээ.
- **Тодорхой газар нутагт хөл хорио тогтоож нийт иргэдийн сэтгэл санаанд дарамт учруулах үйлдлүүдийг цагдаагийн эргүүлийн хэсгүүдээр дамжуулан хийж эхлэв.**

Энэ бүхний үр дагавар болж иргэдийн дунд асар их айдас түгшүүр, төөрөгдөл бий болов.

Иргэний нийгмийн байгууллагууд 2008 оны 7-р сарын 2-ноос зохион байгуулалтад орж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Эхний байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд цензур тогтоон үйл ажиллагааг нь зогсоосныг буруутган мэдэгдэл гаргав⁷. Мөн 700 гаруй иргэд баривчлагдаж хүний амь эрсэдсэн болон олон иргэд ар гэрийнхнийгээ сураглан цөхрөл дунд байгаа мэдээгээр иргэний нийгмийн нэгдсэн мэдэгдлийг гаргав⁸.

2008 оны 7-р сарын 3-наас өмгөөлөгч, хуульч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, оюутан, хүний эрхийн ажилтан зэрэг 100 гаруй хүн сайн дурын үндсэн дээр нэгдэн эмх замбараагүй жагсаал цуглаантай холбоотой хэмээн баривчлагдсан хүмүүсийн нөхцөл байдалд мониторинг

⁷ Хавсралт 2-оос харна уу.

⁸ Хавсралт 3-аас харна уу.

хийхээр баримтжуулалтын багт хуваагдан ажиллаж эхэлсэн. Энэ явцдаа тодорхой тооны баривчлагдсан хүмүүс болон тэдний ар гэрийнхэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, мэдээллээр хангах үйл ажиллгааг давхар явуулав.

Баримтжуулалтын үйл ажиллагааг хүний эрхийн зөрчлийг илрүүлэх зорилгоор асуулгын хуудас бөглүүлэх, баривчлагдахад болон тэдний ар гэрийнхний бичгээр болон амаар өгсөн мэдээллийг бичгээр баримтжуулах хэлбэрээр явагдав. Түүнчлэн баримтжуулалтад оролцогч мэдээлэл өгөгчдийн хүсэлтийг харгалзан дуу, дүрс бичлэг, гэрэл зургийн баримтжуулалт давхар хийгдсэн байна. Үүнийг сийрүүлбэл:

- Баривчлагдсан хүмүүсийн асуулгад – 71 хүн
- Баривчлагдахад ар гэрийнхний асуулгад – 126 хүн
- Аудио бичлэгт - 8 хүн
- Видео бичлэгт - 9 хүн
- Гэрэл зургийн баримтжуулалт – 11 хүн
- Эмнэлгийн үзлэг, шинжилгээгээр - 2 хүн хамрагдлаа

Мөн түүнчлэн баривчлагдахад болон тэдгээрийн ар гэрийнхэн Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Иргэдийн Альянс төв, Нисора сан зэрэг байгууллагын утсаар ярих болон биеэр ирж эрх зүйн болон сэтгэл зүйн туслалцаа зөвлөгөө авлаа.

Дээр дурдсан арга замаар олж авсан баримт мэдээллээр хүний эрхийн холбогдолтой олон улсын эрх зүй, дотоодын хууль тогтоомжийн нэлээд ноцтой зөрчил илрүүллээ. Хүний эрхийн зөрчлүүд нь доорхи эрх зүйн баримт бичгүүдийг зөрчсөн болохыг цуглуулсан баримт нотолгооны үндсэн дээр дүгнэж байна:

- **Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)** – олон улсын хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн тулгуур баримт бичиг бөгөөд хэдийгээр тунхаглалын шинжтэй боловч хүний эрхийн хамгаалалд асар их ач холбогдолтой суурь баримт бичиг
- **Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (ИУТЭОУП)** – бидний ажигласан ихэнхи зөрчил энэхүү Пактын агуулгыг бүдүүлгээр зөрчсөн үйлдлүүд байсан бөгөөд хүний жам ёсны төрөлхөөс заяасан эрхүүдийг багцлан хамгаалсан байдгаараа онцлогтой нэгдэн орсон соёрхон баталсан улсынхаа хувьд заавал биелэгдэх дотоодын хууль тогтоомжтой нэгэн адил эрхтэйгээр үйлчлэх ёстой нэн чухал баримт бичиг юм.
- **Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци** – энэхүү конвенцид эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бус харьцааг үндсэнд нь тодорхойлсон байдаг бөгөөд Монгол улс 2002 онд нэгдэн орсон байна.
- **Хүүхдийн эрхийн тухай конвенци** – Гарсан зөрчлүүдийг ажиглахад насанд хүрээгүй олон тооны иргэд өртсөн нь харагдаж байгаа бөгөөд үүнээс үүдээд энэхүү конвенцийн зүйл заалтыг харах шаардлагатай гэж үзлээ. Монгол улс 1990 онд соёрхон баталсан.
- **Хүмүүсийг хүчээр сураггүй алга болгохоос сэргийлэх конвенци** – 2007 онд нэгдэн орсон
- **Монгол улсын Үндсэн хууль.** 1992 он

- **Эрүүгийн хууль.** 2002 он
- **Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШ).** 2002 он
- **Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих тухай шийдвэрийг биелүүлэх тухай хууль.** 1999 он
- **“Цагдан хорих байрны дотоод журам”** ХЗДХС-ын 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн тушаал
- Дэглэм, журам батлах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол /1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 91 дүгээр тогтоол- **“Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм, журам”**
- Заавар батлах тухай /1994 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 75 дугаар тушаал **“Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар”/**
- Заавар батлах тухай /Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 15/05 дугаар хамтарсан тушаал –**Харуул хамгаалалтын алба хаагч галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх, албаны нохой ашиглах заавар”/**
- **Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хүний эрхийг хангах зарим арга хэмжээний тухай** /Цагдаагийн ерөнхий газрын дарга, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгчийн 1997 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 214/09 дүгээр хамтарсан тушаал/

Дээр дурдсан эрх зүйн актуудаар энэхүү тайлангийн дүн шинжилгээний ажлын хүрээг тодорхойлж байгаа бөгөөд цаг хугацааны хүчин зүйлсээс хамааран орхигдуулсан холбогдох эрх зүйн акт байхыг үгүйсгэхгүй.

ОНЦ БАЙДЛЫН ҮЕЭРХ ХҮНИЙ ЭРХИЙН НИЙТЛЭГ ЗӨРЧЛҮҮД

Бидний цуглуулсан мэдээ баримтаар хүний эрхийн зөрчил нэлээд олон хэлбэрээр гарсан болохыг харуулж байгаа бөгөөд та бүхэнд илүү тодорхой болгох үүднээс доорхи байдлаар бүлэглэн гаргаж ирлээ.

1. Хүний амьд авах эрх:

Онц байдлын үеэр албаны мэдээллээр 5 хүний амь нас эрсэдсэн гэсэн мэдээ байна. Хэдийгээр цагдаагийн буруугаас буюу төрөөс хүний амьд явах эрхэд халдсан гэдэг нь тогтоогдоогүй байгаа ч онц байдал зарлаж цагдаагийн болон дотоодын цэргийн хүч нөхцөл байдлыг хяналтанд аваад байсан тэр үед хүний амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлж чадаагүй нь төр хүний амьд явах эрх, эрх чөлөөг хамгаалах үүргээ биелүүлж чадаагүйтэй холбоотой. Нөгөөтэйгүүр эдгээр амь үрэгдсэн хүмүүсээс гадна олон тооны энгийн иргэд болон цагдаагийн жирийн албан хаагчдын амь насаар дэнчин тавьж нөхцөл байдлыг даамжруулсанаараа холбогдох албан тушаалтнууд хэрхэвч хариуцлагаас мултрах ёсгүй.

Эвслийн баримтжуулалтын баг энэхүү асуудал дээр ажиллаагүй, түүнчлэн УЕП-ын дэргэдэх мөрдөн байцаах албаны эрх үүргийн хүрээнд асуудлыг шалгаж байгаа тул одоогийн байдлаар үүнээс цааш дүгнэлт хийх боломжгүй юм. Гэсэн хэдий ч нэгэнт онц байдалтай

холбоотойгоор хүний амь эрсэдсэн нь хүний эрхийг хамгаалж чадаагүй зөрчил тул дурдах нь зүйтэй гэж үзлээ.


2. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж үл болно:

Ерөнхийлөгчийн зарлигт нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах болон Улаанбаатар хотын төвийн хэсэг/ Бага тойруу/ 22.00- 08.00 цагийн хооронд хөл хорьж, зөрчсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах арга хэмжээ авахаар заасан. Гэхдээ энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хамгаалах үүднээс доор дурсан нөхцлүүдийг анхаарах нь зүйтэй байсан юм:

- **Хэнийг?** - нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа бүлэг
- **Хаана?** - Улаанбаатар хотын төвийн хэсэг/ Бага тойруу/
- **Хэзээ?** - 22.00- 08.00 цагийн хооронд
- **Ямар нөхцөлөөр?** - иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар

Гэсэн хэдий ч Онц байдал зарласан тухай мэдээллийг радио, телевизээр хүлээн авах боломжгүй байсан иргэдэд Ерөнхийлөгчийн зарлигийг толилуулах, түгээх арга хэмжээг бүрэн, шуурхай аваагүйн улмаас цуглаан, жагсаалд оролцоогүй зарим иргэд хоморголон баривчлагдсан явдал нэлээд гарсныг илрүүлсэн. Мөн түүнчлэн иргэний үнэмлэхтэй ч баригдсан, хотын өөр бусад хэсгээс ч баригдсан гэх хүмүүс байсан. Энэ нь:

- МУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 18-д заасан иргэдийн “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” эрхийг
- МУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13 дахь хэсэг “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтуудыг ноцтойгоор зөрчсөн үйлдэл болсон.



Баригдсан хүмүүс ихэвчлэн онц байдал тогтоосон болон сэрэмжлүүлэн анхааруулсныг мэдэхгүй байсан - асуулгад хариулагчдын 91 хувь нь онц байдлын талаар мэдээгүй байсан гэсэн хариулт өгсөн байна. Мөн 94 хувь нь онц байдал болон холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар урьдчилан сануулга сонсоогүй гэжээ. - асуулгаас

Баривчлагдсан хүмүүсийн ихэнх нь “ажлаа тарж яваад”, “салхилж байгаад”, “очоод сонирхож байгаад”, “дуранд төстэй харагдсан учраас гэр бүлийн хүнээ тосох гэж байгаад” баригдсан.- асуулгаас

Баривчлагдсан хүмүүс ихэвчлэн 23.30 –с шөнийн 02 цагийн хооронд Спортын төв ордон, Төв шуудан, Цэцэг төв, Хүнсний 4-р дэлгүүр, Багшийн их сургуулийн хажуу зэрэг газруудаас баривчлагдсан – 28 хүн үймээнийн газраас буюу Сүхбаатрын талбайгаас зайтай газраас баригдсан гэжээ. - асуулгаас



Хоморголон баривчилсан. Миний уулзсан хүмүүс цөм онц байдал зарласныг огт мэдээгүй, 2 нь үймээн болсон газраас хол тухайлбал Баянзүрх дүүргийн Засаг даргын газрын дэргэдээс, ажлынхаа хажуунаас баригдсан байсан. Бүгд эрүүл байхдаа баривчлагдсан бөгөөд тэдний бичиг баримтыг огт шалгаагүй байв. - *өмгөөлөгчдийн тайлангаас.*

Олон улсын гэрээ конвенцид:

ХЭТТ-ын 9-р зүйлд: Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй

ИУТЭОУП-ын 9-р зүйлд:

1. *Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй*

Мөн баривчлагдсан иргэдийн дотор насанд хүрээгүй хүүхэд олноороо байсан нь Хүүхдийн эрхийн конвенцийн 37-р зүйл: (b) *хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хязгаарлаж болохгүй. Хүүхдийг баривчлах, саатуулах, хорих арга хэмжээг хамгийн богино тохиромжтой хугацаанд эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх; мөн түүнчлэн баривчлан саатуулахдаа хүүхдийн эрхийн наад захын стандартуудыг авч үзэх шаардлагатай байсан.*

Үндсэн Хууль /1992 он/

- МУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13 дахь хэсэг *“халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.*

Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002 он):

- 8 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хууль ёсны байх
 - 8.1. *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина.*
 - 8.2. *Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 8.1-ийг зөрчөөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, түүнд хариуцлага хүлээлгэнэ.*

10 дугаар зүйл. Хүний халдашгүй байх эрхийг хангах

- 10.1. *Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч гэмт хэрэгт сэрдэн баривчилж болохгүй.*
- 10.2. *...шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч цагдан хорихыг хориглоно.*
- 10.3. *Прокурор нь хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлж байгаа буюу эмнэлгийн байгууллагад байгаа, эсхүл хууль болон шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа этгээдийг нэн даруй суллах үүрэгтэй.*

Олон тооны иргэдийг хоморголон баривчилсан байдал нь Монгол улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл болохыг дээрхи байдлаар харуулж байгаа бөгөөд тус эвслийн зүгээс энэхүү үйлдлийг эрс буруушааж энэ эрх зөрчигдсөнөөр хүний бусад эрхүүд бүдүүлгээр зөрчигдөх үндэс болсон гэж үзэж байна.

3. Хүнлэг бус, хэрцгий доромжилсон харьцаа, эрүүдэн шүүлтээс ангид байх эрх:

Олон иргэд баривчлагдах явцдаа хүнлэг бус, хэрцгий харьцсан хэмээн мэдээлсэн бөгөөд баривчлах болон саатуулах байр хүргэх үйл явц хүний ёсноос ангид хүнлэг бус байсан гэсэн мэдээлэл ирсэн:



...Би хүмүүсийн доор дарагдсан. Гурав давхарласан хүмүүсийг миний дээр тавьсан. ...Дээгүүр нь дэвсээд өшиглөөд байсан. – видео бичлэгээс


...Намайг явж байхад цагдаа нар дуудсан. Яваад очсон чинь цагдаа нар шууд нүүрлүү бороохойдоод халаасан дахь юмаа гарга гэсэн. Халааснаасаа утсаа гаргаж өгтөл шууд хураагаад авсан. Тэгээд би гайхаад нүүрлүү нь харсан чинь юугаа хараад байгаа юм гээд нүүрлүү дахиад бороохойдоод машинд суулгасан. – видео бичлэгээс

...Машин нь фургон байсан. Биднийг авч яваад 111 т авчирсан. Хүмүүсийг шууд түлхээд буулгаж байсан. Биднийг яг мах ачиж яваа юм шиг авч явсан. Хүмүүс машинаас шууд газар унаж бууж байсан. – видео бичлэгээс

...Анх 4 цагдаа ирж зодоод цагаан машинд дүүрэн хүн чихээд суулгасан. Зарим хүмүүс нь цонхоороо гараад намайг хамгийн доор нь чихээд би амьсгалж чадахгүй агааргүй байсан. – видео бичлэгээс

Санал асуулгын дүнгээс харахад:

Цагдаагийн ажилтны харилцааны байдал



ХЭТТ-ын 5-р зүйлд: Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй

ИУТЭОУП-ын 7-р зүйлд: Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно...

Ийнхүү цагдаагийн албан хаагчдын зүгээс хүнлэг бус харьцаж, доромжилж, хүч хэрэглэх явдал их гарсаныг тарчлаан зовоож, эрүүдэн шүүхийн тодорхой хэлбэрүүдийг агуулсан үйлдлүүд гэж үзэж байна. Эмнести Интернэшнл-ээс гаргасан эрүүдэн шүүхтэй тэмцэх гарыг авлагад эрүүдэн шүүхийн хэлбэрүүдийг:

- Эрүү шүүлт

- Хэрцгий харьцаа / шийтгэл
- Хүмүүнлэг бус харьцаа / шийтгэл
- Доромжлох харьцаа / шийтгэл хэмээн тодорхойлсон байна.

Гэсэн хэдий ч хамгийн өргөнөөр хэрэглэх тодорхойлолтыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан. ...Энэхүү Конвенцийн зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар ялгаварлан гадуурхах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд хамаарахгүй... гэжээ.

МУ-ын Үндсэн хуулийн 16.13-т

... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.

ЭБШХуулийн 10-р зүйл:

10.4. *Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй*

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, баривчлан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 3-р зүйлд

- 3.1. *Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэхэд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтална.*
- 3.2. *Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно.*

Мөн эрүүдэн шүүлтийн **үндсэн элементүүдийг** дурдвал:

- Эрүү шүүлт нь зөвхөн биеийг өвтгөх үйл ажиллагаагаар хязгаарлагддаггүй өвтгөх эсхүл зовоох үйл ажиллагаа нь давтагдсан байдаг,
- Энэхүү үйл ажиллагаа нь зориуд санаатай байдаг,
- Энэхүү үйл ажиллагаа нь зорилготой эсхүл ямар нэгэн төрлийн ялгаварлан гадуурхах үйл ажиллагаатай ямар нэг шалтгаант холбоотой байх ёстой,
- Энэ үйлдэл нь төрийн албан тушаалтайн буюу албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээдүүдийн үйл ажиллагаа, түүний өдөөн хатгалга буюу ил далд зөвшөөрснөөр үйлдэгдсэн байх ёстой.

“Эрүү шүүлтэд шоронд хоригдогсад, сэжигтэн яллагдагч, баривчлагдан саатуулагдсан хүмүүс хамгийн ихээр өртөмтгий байдаг.” – Эмнести Интернэшнл

Эрүүдэн шүүхийн тухай ойлголтод мөн доорхи ухагдахуунууд хамрагдана хэмээн Хүний эрхийн хороо болон Эрүү шүүлтгийн асуудлаархи тусгай төлөөлөгч илтгэлтээ дурджээ Үүнд:

- **Айлган сүрдүүлэлт:** Бие махбодид учруулсан эрүүдэн шүүлтээс үүссэн айдас нь сэтгэл санааны хувьд давхар эрүү шүүлт болдог

Санал асуулгын дүнгээр хариулагчдын 77 хувь нь “цагдаа нарыг хүч болон тусгай хэрэгсэл ашигласан” гэжээ. Мөн 52,1 хувь “биедээ ямар нэг гэмтэл авсан” гэж хариулсан байна. 66 хувь нь “айлган сүрдүүлэлтэд өртөж сэтгэл зүйн дарамтанд орсон” гэжээ.




...“Та нарыг буудах эрх байгаа шүү, 3 жилийн ялтай гэж айлгадаг байсан” гэж ярьж байсан. – *ЧД-ийн цагдаагийн хэлтэст ажилласан баримтжуулалтын багийн тайлангаас*

...Насанд хүрээгүй хүүхдүүдийг байцаахдаа “гэмт хэрэг үйлдсэн чинь нотлогдсон, 2 зүйл ангиар яллагдаж 20 жил шоронд хатаана” гэж дарамт үзүүлснээс сэтгэл санааны их дарамтанд оржээ. – *УМБГ-т ажилласан багийн тайлангаас*



...Бид нарыг бүгдийг алсан ч хамаагүй. Тийм эрх бид нарт байгаа шүү. Та нар мэдэж байна уу үгүй юу гэж байсан. Тэнд байсан хүмүүс маш их айцгаасан. Тэгээд эндээс амьд л гарах юмсан гэж байсан. – *видео бичлэгээс*

...Би байцаагдаж байхад байцаагчийн хажууд нэг хүн ирээд энэ хүмүүс бүгд 5-10 жилийн ял авна шдээ гэсэн – *видео бичлэгээс*



Биднийг баривчлах үедээ болон баривчлах байранд маш их зодсон, цагдаа нар гудамжлан зогсоод машинаас бугаад явах хооронд тэнд хамгаалалтанд зогсож байсан толгойтой бүхэн гартаа байсан зүйлээр зодсон. Баривчлах байранд байхад дээшээ харж болохгүй. Хэрэв дээшээ харах оролдлого хийвэл “Цагдаа руу эгцэлж харах та нар хэн юм бэ. Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. Та нарыг буудах эрхийг Ерөнхийлөгч бидэнд олгосон” гээд байна. Энд байсан хүмүүсийн нэрсийг дуудаад 10-20 хүн болохоор нь машинд ачаад авч яваад байна. Тэдгээр хүмүүс эргэж ирэхгүй байна. Эдний хэлсэнчлэн буудуулаад байна уу гэж би маш айж байна. Биднийг буудах тушаал Ерөнхийлөгч өгсөн нь үнэн үү. Би энэ 3 хоногийг айдас дунд өнгөрөөлөө. Таныг надтай уулзаж байгаа болохоор миний айдас бага болж байна. – *баривчлах байранд ажилласан багийн гишүүний тэмдэглэлээс*

- **Сураггүй алга болгох:** төрийн болон улс төрийн байгууллага, эсхүл тэдгээрийн зөвшөөрлөөр буюу дэмжлэгтэйгээр хүмүүсийг баривчлах, албадан саатуулах буюу хулгайлах, цаашдаа эрх чөлөөг нь тийнхүү хассаныг хүлээн зөвшөөрөхгүй буюу урт удаан хугацааны туршид хуулийн зүгээс хамгаалалтгүй орших зорилгоор эдгээр хүний хувь заяа, эсхүл байгаа газрын талаар мэдээлэхээс татгалзахыг хэлнэ (Олон улсын шүүхийн Ромын дүрмийн 7.1.i)

2008 оны 7-р сарын 4-ний өдөр манай баримтжуулалтын багийнхан баривчлах байр болон цагдаагийн хэлтсүүдийн үүдэнд очиж ажиглалт хийх үеэр манай өмгөөлөгчидөд 7 сарын 1-2 ны шөнийн үймээний үеэр алга болсон хүмүүсийн нэрийг ар гэрийхэн нь өгч байсан ба сургийг гаргаад өгөөч гэсэн хүсэлт тавьж байлаа. Бид тэдгээр нэрсийн дагуу өөрсдийн боломжийн хэмжээгээр сураглаж зарим хүмүүсийн байгаа газрыг тодорхойлж өгсөн ба 2008 оны 7 сарын 8-ны байдлаар 72 хүн болж байсан. Үүнийг цаашид асууж сураглах ар гэрийхэнтэй нь холбогдож баталгаажуулах үйл ажиллагаа явуулснаар 2008 оны 7-р сарын 23-ны байдлаар 49 хүний сургийг гаргаж чадаагүй байсан.

Хэдийгээр эдгээр хүмүүсийн дотор ар гэртэй нь холбоо барих боломж байхгүйгээс мэдээлэл шинэчлэгдээгүй хүмүүс нэлээд хэд байгаа ч цагдаагийн байгууллагаас олон нийтэд мэдээлсэн нэрсийн дунд ч мөн байхгүй байгаа юм. Энэхүү асуудлаар ЦЕГ-тай хамтран шийдэх нь зүйтэй гэж үзээд нэрсийг ЦЕГ-ийн холбогдох албан тушаалтанд гаргаж өгсөн болно.

Түүнчлэн “Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм, журам”-д

30. *Албадан саатуулах байр нь зөвхөн албадан саатуулах тухай шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой үүрэг гүйцэтгэх бөгөөд албадан саатуулагдсан этгээдийн тухай гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь мэдэгдэх, хаана, ямар зөрчлийн учир, хэний шийдвэрээр, хэдий хугацаагаар саатуулагдсан тухай тодорхойлолт хийж өгөх зэрэг бусад байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүргийг саатуулах байрны захиргаа, жижүүрт шилжүүлэн хариуцуулахыг хориглоно;* гэж заасан байдаг ч энгийн иргэдэд хаашаа хандах хэнээс тодруулах ёстой гэдгийг хэлж тайлбарлаж өгөөгүйгээс маш их бухимдал, сэтгэл санааны дарамт учруулсан. Ар гэрийнхний аль боломжтой танил талтай нь хүүхдээ, ах дүүгээ өөрсдөө олж сураглаж гаргаж авч чадсан ба нааш цааш олон дахин явж хөөцөлдөх, хаана очиж хэнтэй уулзахаа мэдэхгүй ялангуяа хөдөөнөөс дөнгөж орж ирсэн буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд маш хүндрэлтэй байлаа.

Дээр дурдсан нөхцөл байдлаас харахад зохион байгуулалт, удирдлага муутайгаас, мөн баривчлагдсан л бол хүний тооноос хасаж үл тоомсорлодог хандлага харагдаж байлаа. Түүнчлэн баривчлагдсан хүмүүсийн ар гэрийнхний сэтгэлийн зовлон, явдал чирэгдэлийг багасгах тал дээр анхаарч ажиллах нь хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болохыг хаа хаанаа анхаарч ажилласангүй.

ЭБШХ-ийн 35-р зүйл

35.4. *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэрэгт сэрдэгдэж байгааг сэжигтэнд тэр даруй, түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчид нь 48 цагийн дотор мэдэгдэнэ.*

ЭХ-ийн 61-р зүйл:

61.1. *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгоно.*



...Би тэр орой нь за хүүхэд минь ирэх байх гээд хүлээгээд байсан. 111-ийн цагдаа нар гэж их хүнд сурталтай цагдаа нар байдаг юм билээ. Би тэгээд эхний шөнө унтаж ч чадаагүй шөнөжингөө хүлээж хоносон. Маргаашнаас нь би бүх газарлуу утасдаж хэлээд хүүхдээ хайгаад байахд “хаана ч байхгүй” гээд байсан. Тэгээд дэнжийн мянгийн 111-ийн утсыг аваад хүүхдээ асуусан чинь манайд тийм ... гэдэг хүүхэд байхгүй гээд л байсан. Би бүр шөнө ч унтаж чадахгүй орондоо уйлж хоносон. Тэр 111-ийн цагдаа нар би эх хүн шөнө ч нойр хүрэхгүй байна чи нэг сургийг нь л гаргаад өгчих гэж гүйсан ч мэдэхгүй тийм хүүхэд байгаа байхаа л гэж хэлсэн. Байгаа байхаа гээд тодорхой хэлээд өгөхгүй байсан. Би тэдэнд их гомдолтой байна. Албаар тэгсэн байх тэд нар. Энэ зүйлийг далимдуулаад тэд нар ар гэрийнхнийг нь хүртэл их дарамталсан. —*видео бичлэгээс*

Тэгээд дараа нь мөрдөн дээр очоод хүмүүсийн нэрсийн жагсаалтнаас хайгаад тэрэн дээр нь байхгүй байсан ингээд 3 хоног болсон ч ямар ч сураггүй олдохгүй байсан. Тэгээд дэнжийн мянгад гарсан хүмүүсийн нэрс дунд шүүлгэсэн чинь байхгүй байсан. ...Тэр жижүүр цагдаа нь олон хүн дундаас ганцхан ... гэдэг хүнийг мэдэхгүй шүү дээ. Хаана ч нэр нь байхгүй байсан. Тэгээд өчигдөр байцаагч дээр очоод ороод асуусан. Байцаагч дээр нь нэр нь байсан. — *видео бичлэгээс*

Тэгэхээр 111-т баригдсан байх гэж бодоод 111-ийн гадна очсон. Үдээш хойш 4 цагийн үед мэдээлэл өгнө гээд өгөөгүй, орой 10 цагийн үед мэдээлэл өгнө гээд өгөөгүй. Ерөөсөө дандаа бөөн чирэгдэл болоод 2 хонолоо, 3 хонолоо ямар ч мэдээлэл өгөөгүй. Тэгээд хагас сайн өдрийн үед Ганц худагт баривчлагдсан хүмүүсийн нэрс дунд нь байсныг мэдсэн. — *видео бичлэгээс*

...7 сарын 1-ний өдөр баригдаад ямар ч мэдээлэл өгөхгүй байж байж л байгаад 7 сарын 5-ны өдөр тэнд баригдсан байгааг мэдсэн. — *видео бичлэгээс*

...Би өөрөө нэг хүний утаснаас нууцаар нэг рүүгээ мессэж бичээд бусдад нь хэлээрэй гэж хэлсэн. Тэгээд нэг цагдаагаас би ар гэрийнхэндээ хэлмээр байна яаж холбоо барих вэ? Ор сураггүй алга болчихоор гайхаж санаа нь зовж байгаа байх гэж асуутал. 48 цагийн дараа ар гэрийнхэнтэй чинь холбоо бариулна гэсэн. Үнэн худлыг нь сайн мэдэхгүй байна. —*видео бичлэгээс*



... Маргааш нь эгч нь залгатал бензин колонкийн тэнд найз нартайгаа явж байгаад баривчлагдсан гэсэн. Өчигдөр орой бүх найзуудыг нь, хүүхдүүдийг гаргасан байна. Найзууд нь гарсан манай хүүхэд гараагүй, сураггүй байсан. Гэтэл өөрөө мессеж бичээд сураг сонсоод мэдэж аваад одоо ингээд хүлээгээд сууж байна — *аудио бичлэгээс*

... Би авгайтайгаа ярих гээд залгасан чинь цагдаа нар наад муу хулгайч чинь бичлэг хийгээд байна гэхээр нь би авгайруугаа л залгасан ш дээ гэсэн чинь намайг гаргаж зодоод чирч өшиглөсөн. — *аудио бичлэгээс*

Дээрхи байдлаар албадан саатуулагдсан хүмүүсийг ар гэрийнхэнд нь мэдэгдээгүй нь зарим талаар саатуулагдсан этгээдүүд холбоо барих хаяг, нэрсээ буруу өгсөнтэй холбоотой ч олон тооны хүмүүсийн ар гэрийнхэн сураглаж ирэхэд чирэгдэл учруулсан байдлаас дүгнэхэд цагдаагийн байгууллагын ажилтнууд хүний эрх, эрх чөлөөнийг наад захын зарчмуудыг зөрчсөн хууль бус үйлдэл хийсэн болох нь тогтоогдож байна.

Хууль сахиулах үед хүч хэтрүүлэн хэрэглэх: эрх чөлөөг нь хязгаарласан этгээдийн нэр төрийг хүндэтгэх ёстой учраас зайлшгүй хүчийг тогтоосон хэмжээнээс илүү хэрэглэх нь хувь хүний эрхийг зөрчсөн гэж үзнэ.

Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх зааварт

1. *Цагдаагийн албан хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар болон, галт зэсэг хэрэглэж довтолсон болон эсэргүүцсэн, нийтийг хамарсан эмх замбраагүй байдал бий болсон буюу бүлэглэн довтолсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүйгээс бусад тохиолдолд хүүхэд болон жирэмсэн эхэд тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно. Харин мэх хэрэглэж болно.*
2. *Энэ зааврын 26-р зүйлийн 1, 2, 3-т заасан тохиолдолд резинэн бороохойгоор хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний тус газар цохих, цахилгаан бороохойгоор хүний нүүр болон биеийн ил хэсэгт хүргэж хэрэглэхийг хориглоно;*
3. *Энэ зааврын 26-р зүйлийн 8-д зааснаас бусад тохиолдолд нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч амьсгал боогдуулагч, резинэн ба хуванцар сумтай буугаар нэг метрээс ойр зайд нүүр рүү шууд чиглүүлэн буудахыг хориглоно;*

Баримтжуулалтын үйл ажиллагааны явцад бид голчлон эрүүдэн шүүлттэй холбоотой гомдол санал баримтуудтай тулгарч байсан бөгөөд баривчлах явцад ихэнхдээ зодуулсан цагдаа нарынхаа хариуг авах замаар баривчлагдсан хүмүүсийн бие эрхтэний ноцтой гэмтэл учруулсан нь аудио, видео болон фото баримтаар нотлогдсон.

Түүний дотор насанд хүрээгүй олон тооны хүүхдүүд өртсөн нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 37-р зүйлд:

(а) хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу суллах боломжгүйгээр бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх тухай заалтыг зөрчсөн үйлдэл болсон.



...гурван хүүхэд ороод 13 настай нэг хүүхэд нь нас барсан. 13 настай хүү өнгөрсөн. Эж нь уйлаад аваад явсан. Тархи толгой руу нь зодоод зодуураа даахгүй өнгөрсөн гэсэн. Энэ 111-ийн ар талаас нууцаар гаргаж авсан юм шиг байна лээ. – *аудио бичлэгээс*

...Тархи толгойг нь хагалсан байсан. Цустай нь хольчихсон. Зогсож ч чадахгүй байсан. – *аудио бичлэгээс*

Мөн эмэгтэй хүн, тэр дундаа жирэмсэн эмэгтэйтэй хэрцгий хүнлэг бус харьцаж байсан тухай гэрчүүдийн яриа бидэнд баримт болон ирсэн байна:

...эмэгтэй хүн байна лээ. Нэг хүүхэн би жирэмсэн шүү дээ гээд орилж байсан. Аймар зодсон байсан. – *аудио бичлэгээс*

...Нэг жирэмсэн эмэгтэйг зодоод алах дөхсөн. Тэгэхээр нь бид нар болиочээ гэж хашгирч байж болиулсан. – *аудио бичлэгээс*

...Цагдаа нар бид нарыг бороохойдсон. Бид хоёрыг олон удаа бороохойдсон. Та нар яадаг юм бэ? Цаашаа бай гөлөгнүүдээ гээд хөөгөөд бороохойдсон. Нэг жирэмсэн эмэгтэйг боройхойдож зодоод алах дөхсөн. Тэгэхээр нь бид нар болиоч ээ гэж хашгирч байж болиулсан. – *аудио бичлэгээс*



...Замын голд манай дүүг 4 цагдаа хэвтүүлээд хайр найргүй өшиглөж зодсон. Та нар болиоч ээ бид нар ямар ч буруугүй зүгээр гэрлүүгээ явж байгаа хүмүүс шүү дээ. Бид нар цуглаан үймээнд оролцоогүй шүү дээ. Та нар ингэж болохгүй болиоч ээ гэсэн чинь “Дуугүй бай янхнууд аа бид нар та нарыг алсан ч хамаагүй бид нарт эрх нь байгаа шүү янхнууд аа” гээд бороохойгоо дээшээ өргөөд орилоод миний нурууруу 2 удаа цохисон. – *видео бичлэгээс*

Эрүүдэн шүүхийн бас нэг элемент болон баривчлагдсан хүмүүст айлган сүрдүүлэх, бие мах бодь болон сэтгэл санааны дарамт шахалт үзүүлэх замаар бие засах, уух, идэх, унтах зэрэг жам ёсны эрх зөрчих замаар саад учруул, хүнийг тэвчишгүй байдалд оруулсан тохиолдол мөн адил гарч байлаа.

Баривчлах, саатуулах, урьдчилан хорих байрны нөхцөл байдал олон улсын баримт бичгүүдэд заагдсан стандартад нийцэж байх нь хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх нэн чухал нөхцөл байдаг. Энэхүү стандарт хангагдаагүйгээс олон хэлбэрийн эрүүдэн шүүлт, хүнлэг бус хэрцгий харьцаа үүсдэг. Баривчлах байрны стандартыг доорхи байдлаар мөрдөөгүй байсан. Баривчлагдагсдыг бүртгэхдээ:

- а. Овог нэр
- б. Баривчлагдсан үндэслэл
- в. Баривчлагдаж ирсэн огноо цаг
- г. Баривчилсан болон хүлээн авсан хуулийн ажилтнуудын овог нэр албан тушаал зэргийн бүртгэл байхгүй байсан.

Ер нь баривчлагдсан хүмүүсийг зохих журмын дагуу шуурхай бүртгэх нь олон талын ач холбогдолтой бөгөөд хэзээ ч хойшлуулшгүй буюу орхигдуулж үл болох үе шат юм. Энэ үйл явц хэр нягт нямбай явагдсанаас баривчлагдагсдыг ангилах, ар гэрийнхэн болон хууль ёсны төлөөлөгчдөд нь мэдэгдэх бусад хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөл болж байдаг.

Баривчлагдан саатуулагдсан этгээдүүдийг ангилах:


- д. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийг боломжийн хэрээр тусд нь хорих,
- е. Боломжгүй тохиолдолд тусдаа өрөө тасалгаанд байлгана

- ё. Насанд хүрээгүй хүүхдүүдийг насанд хүрэгчдээс тусад нь байлгах,
- ж. Шүүхээр ял шийтгүүлээгүй иргэдийг хорих ял эдлэгчдээс тусад нь байлгах,
- з. Насны байдал, хэргийн хүнд хөнгөн болон гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг нь харгалзан ангилж хорих зэрэг болно.

Ийнхүү ангилж байршуулах нь баривчлагдагсадыг бие биенээс нь хамгаалах, харилцан бие махбодь болон сэтгэл санааны нөлөө дарамтанд оруулахгүй байх зэрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан чухал алхам юм.

Санал асуулгын дүнгээр:


Хоригдогсдоос хамгаалагдах боломжийг бүрдүүлсэн эсэх



Хоол тэжээлийн хангалттай байдал:

- и. Цэвэр усны хангамж шаардлага хангасан байна
- й. Хоол хүнсний тэжээлэг, эрүүл ахуйн байдал шаардлага хангасан байна

Хоол тэжээлийн хомсдол нь хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хязгаарласан хүнлэг бус, хууль зөрчсөн үйлдэл бөгөөд хүнд бие махбодь болон сэтгэл санааны хүнд дарамтыг учруулдаг.



...Юу ч өгөөгүй крантны ус 1 түмпэнгээр л өгсөн. Харин Улсын Их хурлын гишүүд ирлээ гээд талх цай өгсөн гэсэн. — аудио бичлэгээс

... 3 хоног юу ч идээгүй. — аудио бичлэгээс


48 цаг болоход 1 л удаа хоол өгсөн. Энэ нь 1 удаа 1 ширхэг боов 3 аяга цай өгсөн. — аудио бичлэгээс



...Хүмүүсийн ам нь цангаанд байсан ч ус байхгүй гээд байсан. Ахлагч нараас ус гуйгаад жижиг пепсиний саванд крантний ус хийгээд зарим хүмүүс нь хувааж ууж байсан. Миний ам цангаж байсан ч би ус уугаагүй надад ус нь олдоогүй. Тэнд ус ууж чадаагүй олон хүн байсан болохоор. — видео бичлэгээс

...Тэгвэл ус өгөөч гэхэд “та нар чимээгүй байвал ус өгнө” гээд байсан. Бид нар чимээгүй байсан ч усаа өгөхгүй байсан. Тэгээд дараа нь 2, 3 сав л ус өгсөн. Тэр ус нь 100 гаруй хүнд хүрэхгүй, ундны усны асуудал хэцүү байсан — видео бичлэгээс

Санал асуулгын дүнгээр:



Баривчлах байрны нөхцөл

- к. Баривчлан саатуулах байрны гэрэл, цэвэр агаарын хүртээмж хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөргүй стандартын шаардлага хангасан байна.
- л. Хүний жам ёсны эрх эрх чөлөөг хангах, ялангуяа бие засах бололцоог хязгаарлаж үл болно
- м. Нийтээр хоригдож байгаа тохиолдолд орны хүрэлцээ, нэг хүнд ногдох талбай хангалттай байх

Баривчлагдсан иргэдийг хорихдоо хэт олноор нь хорих болон гэрэл агаарын хангамж муутай, хэт халуун эсвэл хүйтэн орчинд байх нь баривчлагдагсдын аюулгүй байдал, халдашгүй байдлыг үл хайхарсан хууль бус үйлдэл юм. Ялангуяа гэм буруутай нь нотлогдоогүй иргэдийг жинхэнэ гэмт хэрэгтнүүдтэй хорьж байгаа нь аюулгүй байдалд ноцтойгоор заналхийлсэн явдал болно.

Баривчлагдах байрны нөхцөл байдал муу байх нь баривчлагдагсдын сэтгэл санааны хувьд айлган сүрдүүлэх, эрүүдэн шүүхийн нэг хэлбэр болдог нь олон улсын практикаар нотлогдсон.



...50, 50-аар нь 60, 60-аар суулгаж байсан. ...гадаа нийтийн модон жорлон байсан. Жорлон хүртэл цагдаа нар байсан. Жорлон хүртэл, жорлонгоос гараад явахад нь зодоод хаана байсан тэнд суутал нь зодож байсан. Тэгээд сүүлдээ өглөө цай өгөхөд нь халшраад ус ч уугаагүй, жорлон явбал зодуулна гэж халширдаг болсон – *аудио бичлэгээс*



...Тэгээд бид нарыг наранд ч, бороонд ч гадаа байлгаад буцаагаад гаражд оруулж байсан... Гаражийн байдал нь дотор баахан техник хэрэгсэлүүд байсан. Хүмүүсийг нэг байранд олноор 100 гаруй хүн байсан болохоор ямар ч агааргүй байсан. Бүтэж үхэх гээд байсан. Уг нь дээрээ 3 жижиг цонхтой юм байна лээ. Тэгээд тэр цонхоо онгойлгосон. Тэгсэн ч агааргүй хэцүү байсан. Бүтэх гээд байсан. – *видео бичлэгээс*


...Эхний өдөр гадаа хоносон. Өдөр нь бид нарыг гадаа халуун наранд өдөржингөө суулгасан. Ямар ч ус өгөхгүй байсан. Зарим нь татаад ухаан алдаж байсан. Би эхний өдөр ухаан алдаж унасан. – видео бичлэгээс

...Шээлгэхдээ 2 хэсэг болгон 3 секундын дотор шээлгэж байсан. Шээж амжаагүйг нь гаргаж ирээд зодож байсан. Хоол өдөрт нэг л удаа хоол өгсөн. Ус бараг өгөөгүй. Бид нар борооны ус тосоод канистаранд дүүргэж аваад тэрийгээ ууж байсан. – видео бичлэгээс


...Бид нэг өрөөндөө маш олуулаа байсан. Хүмүүс нь босоогоороо зогсвол багтана. Хэсэг хүмүүс суувал багтахаа байчихдаг байсан. Ямар ч агааргүй байсан. 2 жижиг цонх л онгорхой байсан. Хүмүүс халууцаад ам нь цангацгааж байсан. Цагдаагаас хаалгаа онгойлгочихьё гэхээр үгүй гэж байсан. – видео бичлэгээс

Санал асуулгын дүнгээр:

Өрөөний агаарын хүрэлцээ хангалттай эсэх



Өрөөний гэрэлтүүлэг халуун хүйтний хэмжээ хангалттай эсэх



Цэвэр усны хангамж муу байсан, мөн илчлэггүй, ариун цэврийн шаардлага хангаагүй хоол өгсөн, мөн айдас дарамтны улмаас өгсөн хоолыг идэж чадаагүй гэх зэрэг шалтгаанаар дээрх заалт ноцтой зөрчигдсөн.

Олон тооны хүүхэд, залуучууд энэхүү баривчилгаанд өртсөн бөгөөд насанд хүрэгчидтэй адил зодуур амссан нь бидний баримтжуулалтын явцад тодорхой гарч ирсэн. Бид цагдаа нарт зодуулсны улмаас тархиндаа хүнд гэмтэл авсан хөгжлийн бэрхшээлтэй 16 настай хүүгийн эмнэлгийн магадлагааг гаргуулж аудио видео бичлэгээр баримтжуулсан болно.

Түүний адил олон хүүхэд энэхүү баривчлагааны золиос болон бүх талаар хохирсон бөгөөд эцэг эх, асран хамгаалагчдын боломж бололцооноос шалтгаалаад эмнэлгийн болон хуульзүйн ямар ч туслалцаа авч чадаагүй нь ч бас бий.

4. Саатуулагдсан этгээдүүдийн эрхийг танилцуулах, эрх зүйн туслалцаа авах эрх

ЭБШХуулийн 10-р зүйл:

10.5. Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд голдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна.

Санал асуулгын дүнгээр нийт хариулагчдын **88 хувь** нь эрх үүргийнх нь талаар ямар ч мэдээлэл аваагүй гэжээ.



...Чамаас байцаалт авахдаа чи хуулийн дагуу ийм эрх эдэлнэ, ийм үүрэг хүлээнэ гэж чамд хэлж өгсөн үү?

...Үгүй. Надад тийм юм юу ч хэлээгүй. Тэр байтугай нэрээ ч хэлээгүй. Баривчилсан болон байцааж байсан цагдаагийн хэн нь ч энэ тухай хэлээгүй. Харин байцаалт авч байхдаа цаасан дээр ийм учраас байцаалж авч байгаа гээд бөглүүлсэн тэрэн дээрээс байцаагчийнхаа нэрийг мэдэж авсан. – видео бичлэгээс

18-р зүйл

18.1. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй.

18.2. Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүрэгтэй.

40 -р зүйл:

40.1. Дор дурдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулна:

40.1.2. насанд хүрээгүй;

40.2. Энэ хуулийн 40.1-д заасан тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, түүнчлэн түүний хүссэнээр буюу зөвшөөрснөөр бусад этгээд өмгөөлөгч сонгон аваагүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх уг хэрэгт өмгөөлөгч оролцуулах явдлыг хангах үүрэгтэй.



...Байцаахдаа ямар ч өмгөөлөгчгүй байцаасан. - видео бичлэгээс



...Насанд хүрээгүй хүүхдээс өмгөөлөгч болон сурган хүмүүжүүлэгч, хууль ёсны асран хамгаалагчийн аль аль нь байхгүйгээр шөнийн цагаар байцаалт авсан байсан - өмгөөлөгчдийн тайлангаас

37 -р зүйл:

37.1. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.

35 -р зүйл.

35.2. Сэжигтэн нь дор дурдсан эрх эдэлнэ:

35.2.1. ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх;

35.2.2. өөртэй нь холбогдуулж эрүүгийн хэрэг үүсгэсэн, баривчилсан буюу таслан сэргийлэх арга хэмжээ авсан тогтоолтой танилцах;

35.2.3. баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;



Би нотлох баримт гээд Тэнгист кино үзсэн билетээ үзүүлсэн чинь наадах чинь хамаагүй гээд үзүүлэх болгонд зодож байсан – видео бичлэгээс

35.2.4. мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах;

35.2.5. эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;

35.2.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

35.2.7. өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу өмгөөлөгч авах;

35.2.8. өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах;

35.2.9. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зөвшөөрснөөр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох;

35.2.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

35.2.11. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх.

35.3. Сэжигтэн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэгт холбогдолгүйгээ болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй.

59-р зүйл:

- 59.1. *Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчлах тухай тогтоол үйлдэж, прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна.*
- 59.2. *Тогтоолд баривчилсан үндэслэл, шалтгаан, газар, хугацаа /цаг, минут заасан/, биед нь хийсэн үзлэгийн үр дүн, түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хугацааг тусгана.*
- 59.3. *Тогтоолыг сэжигтэнд танилцуулах ба түүнд энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх, түүний дотор өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхтэй болохыг нь тайлбарлаж өгөх ба энэ тухай тэмдэглэлд тусгана.*
- 59.4. *Тэмдэглэлд түүнийг хөтөлсөн болон баривчлагдсан этгээд гарын үсэг зурна.*
- 59.5. *Хойшлуулишгүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтнийг шууд баривчилж, 24 цагийн дотор тогтоолыг прокурорт болон шүүхэд хүргүүлнэ.*
- 59.6. *Шүүх тогтоолыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор баривчлагдаж байгаа этгээдийг цагдан хорих зөвшөөрөл өгөх буюу суллах үүрэгтэй.*
- 59.7. *Баривчлагдсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оруулан тооцно.*
- 59.8. *Баривчилсан хугацааг сэжигтэнд тогтоол танилцуулсан үеэс эхлэн тоолно.*

60-р зүйл:

- 60.1. *Дор дурдсан тохиолдолд шүүгч захирамж гарган сэжигтнийг суллана:*
 - 60.1.1. *гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт байхгүй;*
 - 60.1.2. *баривчлагдсан этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлгүй бол;*
- 60.2. *Баривчилснаас хойш 72 цаг дуусч, тухайн этгээдийг цагдан хорих шүүгчийн шийдвэр ирээгүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид мэдэгдэж, баривчлах байрны дарга түүнийг суллана.*

81 -р зүйл:

- 81.1. *Сэжигтэн нь сэжигтнээр тооцогдсон болон таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан үндэслэл, түүнчлэн хэргийн талаар өөрийн мэдэж байгаа зүйлийн тухай мэдүүлэг өгөх эрхтэй.*
- 81.2. *Сэжигтнээс мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглоно.*

92 -р зүйл:

- 92.1. *Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад байцаах, нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, хураан авах, үзлэг, нэгжлэг хийх, туршилт, шинжилгээ болон энэ хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулна.*

92.4. *Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.*



Надтай байсан залуу бацаан нар байцаагдана яанаа гэж байсан. Яадгийн гэсэн чинь зодоод байдаг юм гэж байсан. Насны хувьд хөгшин хүмүүсийг зодох нь гайгүй байсан. 14-20 насны залуу хүүхдүүдийг аймаар хэрцгийгээр зодож байсан. – *аудио бичлэгээс*



...Чи тэнд байсан биздээ? чамайг тэнд байхыг чинь камерт харсан шүү гэж тулгаж гүтгэж байсан.

... Дэнжийн мянга дээр очсон шөнөө гадаа хоносон. Маргаашнаас нь байцааж эхэлсэн. Байцаахдаа гадаа шилэн хүзүүн дээрээ гараа аваастай суулгаж байцааж байсан. – *видео бичлэгээс*

...Намайг байцааж байхад би сонсохгүй байна гэхэд наадах чинь надад хамаагүй гэсэн. Би нотлох баримт гээд тэнгист кино үзсэн билетээ үзүүлсэн чинь наадах чинь надад хамаагүй гээд үзүүлэх болгонд зодож байсан. Би 5-р ангид чихний мэс засалд орж байсан. Хоёр чих хоёулаа юм сайн сонсдоггүй. Одоо 2 чих өвдөөд хэцүү л байна.Дараа нь мөн байцаалтан дээрээ зодоход нь мөн ухаан алдаж унасан. – *видео бичлэгээс*

...Тэгсэн нэг хүүхдийн нүүрлүү нулимж байсан. Миний хажууд байсан хүүхдийг дуудаад наашаа ойртоод суу, ойрт ойрт гээд байсан. Ойртоод суусан чинь бөлдөг рүү нь шууд өшиглөсөн. Хойшоо ухарсан чинь. дахиад ойрт гэж байгаад тийшээ нь өшиглөж байсан. Тэнд гарын хээ авч байсан эмэгтэй хүмүүс ч гэсэн муусайн хулгайчууд гээд гарлуу цохиж байсан. Зураг авч байсан хүмүүс бас дарамтлаад та нар юундаа бөгсөөрөө суугаад байгаан бэ? Гараа шилэн дээрээ аваад явган суу гэж дарамталсан. –*видео бичлэгээс*

Санал асуулгад оролцогчдын 66 хувьд хэрэг тулган, өөрийн гэм бурууг нотлохыг шаардаж дарамталсан гэж, 62 хувь нь харгис буюу хэрцгий байдлаар харьцсан хэмээн мэдээлсэн.


144-р зүйл:

144.1. *Байцаалтын эхэнд байцаагдах этгээдийн биеийн байцаалтыг авна.*

144.2. *Байцаалтад дуудагдсан этгээдэд ямар зорилгоор байцаах гэж байгааг урьдчилан тайлбарлан өгч, эрх, үүргийг нь танилцуулж тэмдэглэлд тусгана.*

Санал: асуулгын дүнгээр

Мэдээлэлээр хангагдаж байгаа эсэх



ЭБШХуулийн хүрээнд ХЗДХСайд болон Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан түр саатуулах, цагдан хорих, захиргааны журмаар түр саатуулах тухай журмуудад давтагдсан шинжтэй зүйл заалтууд байх бөгөөд тэдгээрийг мөн зөрчсөн гэж үзнэ.

5. Эдийн засгийн эрхүүд

Баривчлах үйл ажиллагаатай холбоотой гарсан зайлшгүй дурдах хүний эрхийн зөрчлийн нэг нь иргэдийн шударгаар олж авсан эд хөрөнгөтэй байх эрх юм. Иргэдийг баривчлан саатуулах явцад тэдний эд хөрөнгө болох гар утас, хэтэвчтэй мөнгийг хууль бусаар буюу ямар нэг бүртгэл тэмдэглэлгүй хураан авсан тохиолдол нэлээд гарсан.

Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм, журамд:

3.16. *Саатуулагдсан этгээдийг анх хүлээн авахад мөн саатуулах байрнаас гарч яваад ирэх бүрт үзлэг хийж, саатуулах өрөөнд авч орохыг зөвшөөрөөгүй зүйлс илэрвэл тэмдэглэл хөтлөн хураан авч, уг саатуулагдсан этгээдийг хүргэж ирсэн албан тушаалтанд тэмдэглэлийн нэг хувийн хамт хүлээлгэн өгнө.*

31.Албадан саатуулах байранд дор дурдсан баримт бичиг хөтөлнө:

- а/ жижүүрийн илтгэл;*
- б албадан саатуулагдсан этгээдийг хүлээн авсан бүртгэл;*
- в/ саатуулагдсан этгээдээс эд зүйл түр хурааж авсан бүртгэл;*
- г/ саатуулагдсан этгээдээс гаргасан гомдол, хүсэлтийн бүртгэл;*
- д/ албадан саатуулах байранд нэвтрэгсдийн бүртгэл;*
- е/ албадан саатуулагдсан хүмүүсийг байрнаас түр гаргасан бүртгэл;*
- ж/ саатуулагдсан этгээдийг эмчид үзүүлсэн, эмнэлэгт хэвтүүлсэн бүртгэл.*

Ихэнхи мөнгө төгрөгөө алдсан иргэд баривчлагдах үедээ амссан хэрцгий хүнлэг бус харьцаанаас үүссэн айдсаасаа болоод мөн хуулийн мэдлэг хомс байгаагаас ямар нэг гомдол гаргаагүйгээс болж хууль бус үйлдэл хийсэн этгээдүүд болох цагдаа нар хариуцлагаас мултарч байгааг хууль зөрчсөн гэмт хэрэг гэж үзэж байна.

Монгол Улсын дээд шүүхийн тогтоолоор Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай, эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим заалтыг тайлбарласан байдаг. Үүнд: ЭБШХ-ийн 388.1-т хууль зөрчсөн үйл ажиллагаа гэдэгт 389.2-т заасан үйл ажиллагаанаас гадна байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүгдэж, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртсөн, сэтгэл санаа, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамруулж үзнэ гээд эрүүдэн шүүх гэдгийг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахын эсрэг конвенцийн тодорхойлолтыг удирдлага болгоно гэжээ.

Мөн тайлбарт дурдахдаа албан тушаалтны гэм буруугаас үл хамааран учирсан хохирлыг төр хариуцаж арилгахаар заажээ. Үүнд шууд бусаар эд хөрөнгийн хохирлыг ч тооцож төлөхөөр заасан байна. Гэсэн хэдий ч баривчлагдсан хүмүүс, тэр дундаа эрх нь зөрчигдсөн олон иргэд энэ талаар гомдол гаргах байтугай мэдээлэл өгөхөөс эмээж байгаа нь баримтжуулалтын үйл явцад ажиглагдлаа.

ДҮГНЭЛТ

Ийнхүү Монголд анх удаагаа онц байдал зарласантай холбоотойгоор хүний эрх хэрхэн зөрчигдсөнийг ажиглаж баримтжуулах үйл ажиллагаа явагдлаа. Бид өөрсдийн үйл ажиллагааны хүрээг нарийн тодорхойлж гагцхүү Онц байдал зарласан болон түүнтэй холбогдуулан авсан арга хэмжээний үеэр болон түүнтэй холбогдон гарсан хүний эрхийн эрх, эрх чөлөөний зөрчлийг баримтжуулах, албан тушаалтануудад хүний эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийг сануулах, хяналтыг тогтоох зорилгыг агуулж аливаа улс төрийн нөлөөнөөс ангид ажиллахыг зорьсон билээ.

Түүнчлэн бидний үйл хэрэгт тодорхой хүндрэл бэрхшээл учирч байсныг дурдах нь зүйтэй. Үүнээс заримыг нь дурдвал:

- Аливаа улс төрийн шинжтэй хардлагад өртөх,
- Баримтжуулалт явуулах явцад туршлага арга зүй дутагдах,
- Айдас түгшүүрийн улмаас баримтжуулалтад хамрагдахаас татгалзах,
- Эрх зүйн туслалцаа үзүүлэх сайн дурын хүний эрхийн хуульчдаар дутах,
- Иргэний нийгмийн байгууллагуудын санхүүгийн болон бусад шаардлагатай чадавхийн дутагдалтай байх зэрэг болно.

Түүнчлэн бидний үйл ажиллагааг үгүйсгэгчдийн хэлж байгаачлан бид зөвхөн нэг талыг барьж баривчлагдсадын эрх ашгийг хамгаалж байна, гэмтэж бэртсэн цагдаа нарын эрх ашгийг хамгаалахгүй байна гэсэн шүүмжлэл юм. Үүнд тайлбар хийхэд хүний эрхийн зөрчлийг бид төрөөс хүний эрхэд халдаж байгаа үйлдлээр тодорхойлж байна.

Бидний ажигласнаар засаг төрийн албан тушаалтнууд, тэр тусмаа хүний эрх, эрх чөлөөг хамгаална хэмээн Тангараг өргөсөн цагдаа нар хуульд заасан эрх, үүргээ хэтрүүлэн хэрэглэж, хүний эрх, эрх чөлөөнд бүдүүлгээр халдсан гэдэг дүгнэлтийг хийж байгаа юм. Олон иргэдийн эд хөрөнгөд хохирол учруулсан буруутай этгээдүүд хариуцлага хүлээх нь хуульд заасан журмаар хийгдэх ёстой боловч гэмгүй иргэдийг олноор баривчилж, тэдний эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарлаж, харгис хэрцгийгээр хандаж байсныг тодрууллаа. Мөн албан тушаалтнуудын дураар аашлахыг хазаарлах, хүний эрх, эрх чөлөөг ханган

баталгаажуулах хууль, дүрэм, журмыг зөрчиж байгаатай тэмцэх нь иргэний нийгмийн байгууллагууд, идэвхитэн, сайн дурынхан, ер нь нийт иргэдийн журамт үүрэг болж байна.

Анхаарал татахуйц асуудлын нэг нь насанд хүрээгүй хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ үйл явцад ихээхэн хохирсон нь баримтаар нотлогдлоо. Тэдний хөгжлийн бэрхшээлтэй байдал нь тэднийг илүү их эрүү шүүлт амсахад хүргэсэн төдийгүй өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, дохион хэлний орчуулагч нарыг байлцуулалгүй байцаалт авсан нь хууль бус үйлдэл буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ноцтой алдаа болсон хэдий ч энэхүү байдлыг прокурорын байгууллагаас хангалттай анхаарч ажиллаагүй нь харамсалтай.

Ийнхүү эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны явцад олон хууль бус үйлдэл гарсан нь нотлогдсон учраас цаашид үргэлжлэн хоригдож буй иргэдийн хувьд энэхүү байдлыг үнэн зөвөөр мэдээлэх нь тэдний амь нас, амьдралд олон талаар нөлөөлөх юм. Төлбөрийн чадвартай олон иргэд батлан даалтанд гарсан ба харин эрх зүйн туслалцаа авах чадваргүй, энэ талаар мэдээлэл байхгүй иргэд хоригдон үлдсэн нь сэтгэл зовоож байгаа асуудлын нэг болоод байна.

Хүний эрхийн мониторингийн эвслийн зүгээс төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан МУ-ын ХЗДХЯ-ны холбогдох албан тушаалтнуудад эрх зүйн туслалцааны талаар анхаарч ажиллахыг хүссэн албан тоот хүргүүлсэн. Гэвч ХЗДХЯ-ны зүгээс эвсэлд тодорхой хариу ирүүлээгүй байна. Эрх зүйн туслалцаа авч чадаагүй иргэд ТББ-д ажиллаж байгаа өмгөөлөгч нарт олноор хандаж байгаа тул насанд хүрээгүй хүүхэд болон төлбөрийн чадваргүй гэж үзсэн байгаа 60 гаруй иргэдэд өмгөөлөл үзүүлж эхлээд байгаа бөгөөд эрх зүйн туслалцааны асуудлыг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Эвсэл цаг хугацааны хувьд яаралтай байдлаар зохион байгуулагдсан хэдий ч өөрсдийн боломжийн хэмжээгээр нөлөөллийн үйл ажиллагааг явууллаа. Тухайлбал:

- 2008 оны 7-р сарын 7-нд УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанд оролцож өөрсдийн олж авсан баримт, нотолгоог танилцуулснаар хүний эрхийн нөхцөл байдалд УИХ-н зүгээс тавих хяналтыг сайжруулахад дөхөм өгсөн гэж үзэж байна.
- 2008 оны 7-р сарын 8-ны өдөр хэвлэлийн бага хурлын үеэр өөрсдийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлсэн нь бидний ойлгож байгаагаар цагдаагийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагуудад хүний эрхийн зөрчил дахин гаргуулахгүй байх тал дээр анхаарч ажиллах сануулга болсон гэж үзэж байна.

Баримтжуулалтын багийн зүгээс баривчлагдсан хүмүүс тэдний ар гэрийнхэн маш их айдастай байсан ч өөрсдийн аюулгүй байдал, эрсдэлийг үл харгалзан бидний үйл ажиллагаанд оролцож мэдээлэл өгсөнд нь талархал илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнээс үүдэн тэдний зөвшөөрөлгүйгээр тэдний нэр хаягийг олон нийтэд мэдээлэхгүй байх ёс зүйн хариуцлагыг энэхүү эвсэл үүрч байгаа дурдах нь зүйтэй.

Цаашид эвслийн үйл ажиллагааны үргэлжлэл болж Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр Глоб Интернэшнл ТББ-аас “Онц байдлын үеэрхи буюу 2008 оны 7-р сарын 1-9-нийг дуустал хугацаанд гарсан хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүний эрхийн зөрчлийг хэрхэн тусгасан болон тэдний зүгээс хүний эрхийн ямар зөрчил гаргав” гэдэг асуудлаар мониторинг, Хууль - Хүний эрх төвөөс 7-р сарын 1-ний үеэр баривчлагдсан иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Хүний эрх, эрх чөлөөний байдал ноцтой зөрчигдөж байгаа энэхүү нөхцөл байдалд нэгдэн ажилласан хүн бүрт талархал илэрхийлэе. Эвслийн зүгээс өөрийн үйл хэргийг нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн явдал гэж үзэж байгаа бөгөөд төр засагт тавих хяналтыг илүү сайжруулахад хүний эрхийн хуульчид, судлаачид, ТББ-н идэвхитэн, хүний эрхийг хамгаалагч нар цаашид ч хамтран ажиллана гэдэгт найдаж байна

Эцэст нь, хүний эрх, эрх чөлөө нь түгээмэл шинжтэйн зэрэгцээ мөн хувийн шинжтэй гэдгийг онцлох нь зүйтэй. Учир нь нэг хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн баримт нь 10, 100, 1000 хүний эрх зөрчигдсөн баримттай адил тооцогддог. Эвслийн болон бусад иргэний нийгмийн байгууллагуудын энэхүү хичээл зүтгэл нь монголын нийгэмд анх удаа бий болсон энэхүү аймшигт үйл явдалд төр болон нийгмийн зүгээс хэрхэн харж зохицуулж байгаа нь цаашид жишиг болон тогтох учир алсыг харж ардчилсан зарчмыг удиртгал болгон хууль ёсыг дээдлэн зохицуулах нь чухал байна. Чингээд аливаа хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэдгийг нотлох, зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хамгаалах, гарсан хохирлыг арилгуулах, түүнийг тооцон барагдуулах үүрэгтэй засаг, төрийн байгууллагууд, албан тушаалтны үүргийг сайжруулах зорилтыг цаашид тавьж ажиллах нь зүйтэй байна.

ХАВСРАЛТ 1

ОНЦ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХҮНИЙ ЭРХИЙН МОНИТОРИНГ, ХАМГААЛЛЫН ЭВСЭЛ

Алхам алхмаар хөгжлийн төлөө ТББ

Ардчиллын төлөө олон улсын иргэний
нийгмийн чуулганы Азийн төлөөлөгч

Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг

Глоб интернэшнл ТББ

Иргэдийн альяанс төв

Иргэн Д.Ламжав

Их британий хүүхдийг ивээх сан

Монголын эмэгтэйчүүдийн сан

Монголын эмэгтэйчүүдийн холбоо

Монголын эрэгтэйчүүдийн холбоо

“Монгол өрх” сэтгэл заслын холбоо

Нисора хөгжлийн сан

Нээлттэй Нийгэм Форум

Өсвөр үеийнхний хөгжлийн төв

Тэгш мөр төв

Филантропи хөгжлийн төлөө төв

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
байгууллагуудын үндэсний холбоо

“Хөгжицгөө” клуб Хүний эрх хөгжил төв

Хууль хүний эрх төв

Хүний эрх хөгжил төв

Хүүхдийн эрхийн үндэсний төв

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Эмнэсти интернэшнл

ХАВСРАЛТ 2**МЭДЭГДЭЛ**

2008 оны 7-р сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

2008 оны 7-р сарын 1-ний өдөр болсон олон нийтийн жагсаал цуглааны дараа бий болсон нөхцөл байдал нь хүчирхийлэлд хүрч хэд хэдэн хүний амь нас эрсдэн, олон хүний эрүүл мэнд хохирч, соёлын үнэт зүйлс, байгууллага, иргэдийн өмч хөрөнгө устсан явдалд гүнээ харамсаж байгааг илэрхийлж байна. Энэ нь олон жил Монголын нийгэмд бугшсан шударга бус явдал, авилгын эсрэг нийгмийн тодорхой хэсгийн уур бухимдалын туйлширсан илрэл гэж үзэж байна.

Нийгэмд эмх замбараагүй байдал үүссэн эгзэгтэй үед улс төрийн намууд өөрийн явцуу эрх ашгийг урьтал болгож, хүний амь нас, хүний эрх, эрх чөлөөг огоорч, улс төрийн ашиг хонжоо хайж байгааг харамсаж байна.

Үүссэн нөхцөл байдалд төр, засаг бодитой дүгнэлт хийж, зохистой арга хэмжээг шуурхай авч чадсангүй. Цагдаа, иргэдийн дунд мөргөлдөөн болсон нь зөрчлийг тайван замаар зохицуулах, жолоодох сэтгэл, ур чадвар цагдаа, хүчний байгууллагын удирдлагад илт дутсантай холбоотой гэж үзэж байна.

Онц байдал зарласантай холбогдуулан хүний салшгүй эрхэд зарим хязгаарлалт хийгдэж байгааг зайлшгүй шаардлагатай гэж үзэхгүй байна. ОНҮРТ-ээс бусад радио, телевиз болон мэдээллийн сайтуудыг хааж, төрийн цензур тогтоож, иргэдийн мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласаныг зайлшгүй шаардлага гэж үзэхгүй байна.

Ийм онцгой байдлын үед баривчлан саатуулагдсан хүмүүсийн ар гэрээс эрүү шүүлтээс ангид байх хүний салшгүй эрх зөрчигдөж байгаа тухай мэдээлэл ирж байгаа нь бидний сэтгэлийг түгшээж байна. Баривчлагдан саатуулагдсан 700 гаруй гэх иргэний хүний эрхийн зөрчилд хяналт тавих боломжийг иргэний нийгмийн байгууллагуудад олгож тэдгээр иргэдийн өмгөөлүүлэх эрхээ эдлэх нөхцлөөр хангахыг шаардаж байна.

Зугатаж байгаа иргэний араас хөөж амь насыг нь хөнөөсөн жигшүүрт хэрэг үйлдсэн этгээдийг яаралтай тогтоохыг мөн шаардаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Онц байдал зарлах тухай зарлигийг үйл явдалд газар дээр оролцож байсан болон ажиглаж байсан хүмүүст төрийн зүгээс зохих ёсоор хүргээгүй байж хүч хэрэглэснийг хүний эрхийн ноцтой зөрчил гэж үзэж байна.

Хүний эрхийг дээдлэн асуудлыг шийдвэрлэх тайван арга зам Монголын нийгэмд байгаа гэдэгт итгэх итгэл суларсныг болсон явдал тод харууллаа. Иймээс ардчиллын үндсэн институциудыг бэхжүүлэх, чөлөөт шударга сонгуульд итгэх иргэдийн итгэлийг сэргээхийн төлөө төр засаг, улстөрийн бүх хүчин, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд эрчимтэй хамтран ажиллахыг уриалж байна.

Мэдэгдэл хийсэн:

Нээлттэй нийгэм форум

Хүний эрх, хөгжил төв

Глоб интернэшнл

Филантропи хөгжлийн төлөө төв

Хүний эрх хууль төв

Монголын эмэгтэйчүүдийн сан

Ардчиллын төлөө олон улсын иргэний
нийгмийн чуулганы Азийн төлөөлөгч

Хүний эрх, ардчиллын судалгааны төв

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Иргэдийн альянс төв

ХАВСРАЛТ 3

ОНЦ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХҮНИЙ ЭРХИЙН МОНИТОРИНГ, ХАМГААЛЛЫН ЭВСЛИЙН МЭДЭГДЭЛ

2008 оны 7-р сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд,
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевизийн Ерөнхий Захирал М.Наранбаатар,
Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн Захирал Т.Мөнхбаатар,
Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн Захирал Б.Пүрэвдаш нарт:

МҮОНРТВ нь “гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг, хараат бус, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэдэг, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэдэг, ... албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус гагцхүү нийт үндэсний эрх ашгийг дээдэлдэг”, “аливаа хөтөлбөр нь үнэн бодит мэдээлэл агуулсан, мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, нэг талыг баримтлаагүй, сэтгүүлчийн ёс зүйн зарчмыг баримталсан, шуурхай байх” ёстой.

Түүнчлэн МҮОНРТВ нь Монгол улсаас нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенци, ардчилсан Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Онц байдлын тухай хууль зэргээр баталгаажсан иргэн хүний эрх, эрх чөлөө хэрхэн зөрчигдөж байгааг хуульд заасан дагуу ил тод, нээлттэй мэдээлэх үүрэгтэй.

Гэтэл дээрхи хуулиуд онц байдал тогтоосон өдрүүдэд туйлдаа хүртэл зөрчигдлөө. Тухайлбал, Гэрээний эрхийн тухай Венийн Конвенцид заасан “оролцогч улсууд гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо хуулийн заалтыг баримтлан зааж үл болно”, Онц байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд “энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дагуу хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, ...түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгийн хандахыг хориглосон Үндсэн хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан.

МҮОНРТВ нь гагцхүү иргэдийн нийтлэг эрх ашигт үйлчлэх ёстой атал иргэдийн мэдэх эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдөж байгаа энэ аюултай мөчид ганц талыг баримтлан ажиллаж, гагцхүү албан тушаалтны өгсөн үүргийн дагуу ажиллаж, олон түмнийг төөрөгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байгаад хүний эрхийн байгууллагууд бидний дургүйцлийг төрүүлж байна.

Тиймээс та бүхэн онц байдал тогтоосон өдрүүдэд гарсан хүний эрхийн зөрчлүүдийн талаар олон эх сурвалжаас нөхөн мэдээлэх шаардлагатай гэж үзэж байна. Ялангуяа хүний эрхийн хуульчид, хүний эрхийн төлөө ажиллаж байгаа сайн дурын ажилтнууд, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэд, амь нас, эрүүл мэндээр хохирсон иргэдийн гэр бүл, төрөл садангийн мэдээлэл хамгаас илүү чухал байна.

Мэдэгдэл хийсэн:

Хүний эрх хөгжил төв	Монголын эмэгтэйчүүдийн сан
Хууль хүний эрх төв	Алхам алхмаар ТББ
Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	“Хөгжицгөөе” клуб
Нээлттэй нийгэм форум	Эмнэсти интернэшнл
Глоб интернэшнл	“Цэх” ТББ
Филантропи хөгжлийн төлөө төв	Хуульч эмэгтэйчүүдийн холбоо

Эрэгтэйчүүдийн холбоо

“Монгол өрх” сэтгэл заслын холбоо

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
байгууллагуудын үндэсний холбоо

ЭКПАТ-ын үндэсний сүлжээ

“Хүүхэд хамгаалал” эвсэл

Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг

Иргэдийн альяанс төв

Ардчиллын төлөө олон улсын иргэний
нийгмийн чуулганы Азийн төлөөлөгч